



## П.Н.ШАСТИНЫ НЭРЭМЖИТ КЛИНИКИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ




Клиникийн Төв эмнэлэг 1954 оны 9-р сарын 21-нд "Мэс заслын эмнэлэг" нэртэйгээр 115 ортой, 9 эм, 118 ажилтантай анх байгуулагдсан ба 1960 онд Оросын алдарт эмч П.Н.Шастины нэрэмжит болгосон. Тус эмнэлэгт Монгол улсад алдартай олон эрдэмтэн, гавьяат эмч нар ажилладаг бөгөөд 114 эмч, 283 сувилагч ба дунд мэргэжилтэн, 221 ажилтантай. Стационарын 420 ортой 38 эмчилгээ, оношлогоо, аж ахуйн тасагтай.

"Цаасгүй эмнэлэг" удирдлага мэдээллийн нэгдсэн сүлжээг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн анхны эмнэлэг юм. Тус

эмнэлэгт академич 2, шинжлэх ухааны доктор 6, анагаах ухааны доктор 21, клиникийн профессор 15, тэргүүлэх болон ахлах зэрэгтэй эмч 40 гаруй, бакалаврын зэрэгтэй сувилагч 25 ажилладагаас гадна анагаах ухааны салбарт тэргүүлэх эрдэм шинжилгээний товхимол, илтгэл 1000 гаруйг бүтээсэн байна.

Хаяг: БГДүүрэг, Ард Аюуш-1 гудамж.  
Утас: 68788, Факс: 976-11-687886,  
E-mail: shastinhospital@magivnet.mn

## Н.ДАШИЙН НЭРЭМЖИТ ГЭМТЭЛ СОГОГ СЭРГЭЭН ЗАСАХ КЛИНИКИЙН ЭМНЭЛЭГ



1960 онд Улаанбаатар хотын клиникийн 1 дүгээр эмнэлэгт гэмтлийн тасаг 20 ортой анх байгуулагдсан.

1972 онд эрүүл мэнд, нийгэм хамгааллын яамны харьяа бие даасан гэмтлийн эмнэлэг болж өргөжин, 1990 оноос клиникийн эмнэлэг болсон. Тус эмнэлэг нь 420 ортой, 72 их эмчтэй, 200 сувилахуйн мэргэжилтэнтэй улсын хэмжээний үйлчилгээг үзүүлж байна. Сүүлийн 5 жилд 183889 хүнд яаралтай тусламж үзүүлж, 44.2 мянган өвчтөнг хэвтүүлж эмчлэв.

Хаяг: БГДүүрэг, Чингүнжавын гудамж.  
Утас/Факс: 976-11-687795



## Н.ГЭНДЭНЖАМЦЫН НЭРЭМЖИТ ЭХ НЯЛХСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ ЭМНЭЛЭГ

Тус төв нь 1930 онд 15 ортой хүүхдийн тасаг, 1952 онд 100 ортой хүүхдийн тасаг, 1987 онд 662 ортой Эх нялхсын Эрдэм Шинжилгээний төв болон ажиллаж байна. 2005 оны байдлаар тус төвийн Эрдэм шинжилгээний салбар, 3 клиник, 35 тасаг нэгжид 968 эмч, эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтан, эмнэлгийн болон эмнэлгийн бус мэргэжилтэн ажиллаж байна.



Үүнд: Академич 1, Шинжлэх Ухааны доктор 3, Анагаах Ухааны доктор 12, Профессор 3, Клиникийн профессор 9, Шинжлэх Ухааны магистр 16, Анагаах Ухааны магистр 56.

Тус төвийн клиникууд нь өөр өөрийн онцлогтой бөгөөд Монгол улсын хэмжээнд дараах мэргэжлийн эмчилгээ үйлчилгээг үзүүлдэг онцлогтой.

1. Эх барих эмэгтэйчүүдийн клиник
2. Хүүхдийн дотрын клиник
3. Хүүхдийн мэс заслын клиник

Эх нялхсын эрдэм шинжилгээний төв Жилдээ 27000 эх, хүүхэд хэвтэн эмчлүүлдэг, 6000 орчим эх төрдөг, 10500 орчим мэс заслын эмчилгээ үзүүлдэг, 2 зөвлөх поликлиникээр 130000 эх, эмэгтэйчүүд, хүүхдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үзүүлдэг.

Хаяг: БГДүүрэг, 11-р хороо, Амарсанаагийн гудамж,  
Утас/Факс: 976-11-362633,  
E-mail: mshrs-jen@megic.net.mn





## "БАЯНГОЛ" ЭМНЭЛЭГ



"Баянгол" эмнэлэг нь 2002 онд хэвтүүлэн эмчлэх 25 ортой стационарын хэсэг, амбулатори, мэс заслын тасаг, эмчилгээний гоо сайхан, саун, нөхөн сэргээх физик эмчилгээ болон туслах салбарууд ашиглалтанд орсон. Өнгөрсөн хугацаанд гадаад, дотоодын нийт 90 гаруй мянган үйлчлүүлэгчдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн бөгөөд Өрнийн болон Дорнын анагаах ухааныг, эмийн бус, нөхөн сэргээх эмчилгээтэй хослуулан үр дүнтэй эмчилгээ, оношлогоог явуулж ирлээ.

Эмч 48, Ахлах зэргийн эмч 49, зэрэгтэй сувилагч, эмнэлгийн ажилтан 57 ажиллаж байна.

1998 оноос төгсөлтийн дараах сургалт эхэлж, 2000 онд ЭМЯ-ны зөвшөөрөл авсан, Бүгд 45 резидент, 5 их эмч мэргэжил дээшлүүлж байна, 2000 оноос хойш 126 их эмч, 126 сувилагч, 39 эх баригч мэргэжил дээшлүүлсэн.

Сүүлийн жилүүдэд гадаад харилцаагаа хөгжүүлж Герман, Япон, АНУ, Казакстан, Солонгос, Австрал зэрэг улс оронтой зүрх судас, цусны өвчин, уруул тагнайн согог, бөөр, нүдний мэс засал зэрэг чиглэлээр хамтран ажиллаж зохих үр дүнд хүрч байна.

Хаяг: БГДүүрэг, 11-р хороо, Хасбаатарын гудамж 1-1,  
Утас: 99117815, 99096587,  
Факс: 976-11-305903, E-mail: met@mobi.net

## "АЧТАН ЭЛИТ" КЛИНИКИЙН ЭМНЭЛЭГ



Тус эмнэлэг нь 200-05-05-ны өдрөөс үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд 2003 оны 12-р сард 60 ортой өргөтгөлийг ашиглалтанд оруулан ажиллаж байна.

25 их эмчтэй, сувилагч-32, дунд мэргэжилтэн-9, бусад ажилтан 34, нийт 100 гаруй ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Орон тооны бус зөвлөх доктор, профессор 9 ажиладаг.

Нэг ээлжинд 200 хүн хүлээн авч үйлчлэх нарийн мэргэжлийн 20 гаруй кабинет бүхий поликлиниктэй, хоногт 150 хүн хэвтүүлэн эмчлэх чадавхи бүхий дотор, мэдрэл, уламжлалт эмчилгээ, мэс засал, эмэгтэйчүүдийн болон бичил мэс заслын тасагуудтай болтлоо өргөжин үйл ажиллагаа явуулж байна.

Хаяг: БДГ 6-р хороо Ард Аюушийн 1а,  
Ерөнхий эмч, Доктор, профессор Цүрэмийн Мухар  
Утас: 689623, 689624, 680333




## АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

Манай дүүрэгт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний Номин электроникс, Нарлаг, Ачлал, ТБД андууд, Хан бүрэгдэй, Боса, Алтжин, Барс, ХарХорин, Материал импекс, Дэвшил трейд, Агро Амгалан зэрэг 3500 гаруй аж ахуйн нэгж, компаниуд, худалдаа үйлчилгээний төвүүд үйл ажиллагаагаа явуулж байна.



### **МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ**

Манай дүүрэгт орших Монголын Төмөр Замын Хэрэг эрхлэх Газар нь Монгол улсын нийт ачаа эргэлтийн 80 хувийг, зорчигч тээвэрлэлтийн 60 гаруй хувийг гүйцэтгэж байдаг



### **ДӨРӨВДҮГЭЭР ЦАХИЛГААН СТАНЦ**

Манай дүүрэгт 2,4-р дулааны цахилгаан станцууд, Дулааны сүлжээ ХКомпани зэрэг эрчим хүчний томоохон газрууд байрладаг.

## **"УЛААНБААТАР ПАЛАС" ХХК**

"Улаанбаатар палас" ХХК нь 1999 онд үүсгэн байгуулагдсан ба шоу бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг шилдэг аж ахуйн нэг юм.

Улаанбаатар палас ХХК нь 3058 хүний суудалтай концертийн танхим, 3500 хүний суудал бүхий 20000 хүн хүлээн авах хүчин чадалтай задгай талбай, 1200 хүн хүлээн авах "Лазерланд" диско клуб, 180 хүн хүлээн авах "Рок 69" шөнийн клуб, 24-30 хүний суудалтай 3 өрөөтэй "Од" караоке баар, "Хүрхрээ" баарандаа нийт 800000 орчим хэрэглэгчидтэй, 200 орчим ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна.



Компаний захирал О.Баяр  
Хаяг: БГД, Ү1 хороо, Улаанбаатар палас комплекс  
Факс: 976-11-688130  
Утас : 688240, 682892  
E-mail: uuregtrade@magicnet.mn





## "ТБД" АНДУУД ГРУПП



ТБД андууд ХХК анх 1992 онд үүсгэн байгуулагдсан ба Баянгол дүүргийн нутаг дэвсгэр дээр 3500 кв.м үйлчилгээний талбай бүхий орчин үеийн худалдаа үйлчилгээний төвд гадаад, дотоод худалдааны чиглэлээр үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна. Өөрийн үйл ажиллагаагаа өргөжүүлж Герман улсад төлөөлөгчийн газраа нээн Германы болон Баруун Европын томоохон фирмүүдтэй харилцаа холбоо тогтоон хамтран ажилладаг.

Компаний захирал С.Баасанхүү

Хаяг : БГД, 2-р хороо, Энх тайвны өргөн чөлөө,  
ТБД андууд ХХК  
Факс: 976-11-361055  
Утас : 361192

E-mail: tbd-anduud@magicnet.mn and

## "ЧИНГИС ТРЕЙД" ХХК



"Хар хорин" худалдааны төв 1993 оны 12 дугаар сарын 22-ны өдөр үүсгэн байгуулагдсан. Тус худалдааны төв нь Баянгол дүүргийн 5-р хорооны нутаг дэвсгэр дээр худалдаа, үйлчилгээ эрхлэх 8.2 га талбайд 130 гаруй ажиллагсадтай, 1100-1300 хүн чөлөөт худалдаа, үйлчилгээ эрхэлж, өдөрт дунджаар 2500-3000 орчим хүнд үйлчилж байна.

Компаний захирал Ч.Лхагвадорж

Хаяг : БГД, 20-р хороо, Энх тайвны өргөн чөлөө,  
"Хар хорин" Худалдааны төв  
Факс: 976-11-633967  
Утас : 683970

## "АЧЛАЛ ТРЕЙД" ХХК

"Ачлал трейд" ХХК нь гадаад дотоод худалдаа, үйлчилгээ, нийтийн хоол, барилга угсралт, заслал чимэглэлийн чиглэлээр 1997 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж байна.

Компаний захирал М.Бэлэгт

Хаяг : БГД, Ард Аюушийн өргөн чөлөө  
Факс: 976-11-367990  
Утас : 369703  
E-mail: achlal\_trade@magicnet.mn





## СОЁЛ УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГУУД

Манай дүүрэгт Монголын Төрийн их шүтээн Жанрайсаг, Бурхан шашны Төв Гандантэгчэнлин хийд, Монголын радио телевизийн Хэрэг эрхлэх газар, Улаанбаатар телевиз, МҮЭСТОрдон, Төмөр замын дуу бүжгийн чуулга, Улаанбаатар палас, Од, Өргөө кинотеатр, Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим, Элгэн нутаг FM-100.8 104, Хөх тэнгэр радио зэрэг соёл урлаг, мэдээллийн хэрэгслийн томоохон төвүүд үйл ажиллагаагаа явуулж байна.

### МОНГОЛЫН БУРХАН ШАШНЫ ТӨВ ГАНДАНТЭГЧЭНЛИН ХИЙД



Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдийг анх 1838 онд V Богд Жавзандамба үүсгэн байгуулсан түүхтэй.

Анх байгуулагдахдаа найман сүм, дацан, 500 лам хуврагатай байсан байна.

Одоо тус хийд нь 10 дацан, сүм дугантай, 900 орчим лам, хуврагатайгаар үйл ажиллагаагаа явуулж сүсэгтэн олондоо буяны үйлчилгээг үзүүлж байна.


Гандантэгчэнлин хийд  
Утас: 360164  
Факс: 976-11-360354  
И-майл: mbcgandan@magicnet.mn



### Төмөр замчдын дуу бүжгийн чуулга

Төмөр замчдын чуулга нь 1991 онд үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Тус чуулга нь 400 хүний суудалтай үзэгчдийн болон цэнгээнт бүжгийн танхимтай. Тус чуулгын урын санд Монголын язгуур урлагийн төрлүүд болон шашны зан үйл, ёслолыг тусган харуулсан бүжгүүд багтдаг.

Захирал: Д.Нямаа  
Утас: 944580  
Факс: -976-11-944580







## ӨРГӨӨ КИНОТЕАТР



Өргөө кинотеатр нь анх 1990 онь: 10-р сарын 5-нд үүд хаалгаа нээсэн, Улаанбаатар хот дахь отгон кинотеатрын нэг юм. Тухайн үедээ СТА Д.Баатар даргатай тус кинотеатрын хамт олон нь их, бага 2 танхимтай, 25000 үзэгч хамарсан соёлын арга хэмжээ, кино үзвэр зохион байгуулж байв.

Эдүгээ "Нью тур сафарис" ХХК-ний харьяа тус кинотеатр нь Д.Сэндмаа захиралтай, хамт олон нь монгол киногоор нийтэд үйлчилдэг цорын ганц театр юм.

Гол төлөв "Орчлон", "Чингис фильм" студийн бүтээлүүдээр иргэддээ үйлчилж байна. Түүнчлэн хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулан диско, бильярд, спорт, урлагийн хөгжөөнт тоглоомууд, нийтийн цэнгээнт бүжгээр ард иргэддээ үйлчилж байна.

## МОНГОЛЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮДИЙН СОЁЛЫН ТӨВ ОРДОН



Тус ордон Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт Энхтайваны өргөн чөлөөнд байрлалтай.

12000 ам метр талбайтай. 1000 хүний суудалтай концертын, 300 хүний суудалтай хурал зөвлөгөөний танхимтай бөгөөд эдгээр танхимууд нь 6 хэлээр зэрэг орчуулах төхөөрөмж, дотоодын теле нэвтрүүлгийн систем, кино гаргах техник хэрэгслээр тоноглогдсон.

Үүнээс гадна 200 хүний суудалтай 900 шахам метр ам дөрвөлжин метр талбайтай биеийн тамирын танхим, мөн номын сан, уншлагын газар, үзэсгэлэнгийн болон хичээл сургалт явуулах тусгай тоноглогдсон анги танхимуудтай.

Ордонд жилд дунджаар 280-350 ажил, арга хэмжээ зохиогддог юм. Сүүлийн жилүүдэд мэргэжлийн урлагийн зарим байгууллагатай хамтран Англи, Франц, Япон дуу дуулаачдын уралдаан, ардын уламжлалт дуут тоглоом "Дэмбээний наадам", дуучин гэр бүл шалгаруулах тоглолт болон Баян хуур хөөрөгт хөгжим тоглогчдын, Ардын цөөхүүл хөгжимчдийн, морины тухай дуу дуулаачдын, мэргэжлийн морин хуурчдын зэрэг улсын чанартай олон арга хэмжээ зохион байгуулсан нь үзэгчид уран бүтээлчдийн талархлыг хүлээж байгаа билээ.

Захирал Ж.Баасанханд  
Утас 329603  
Факс: 976-11-329603  
Гар утас 91914239



## ДҮҮРГИЙН ТОХИЖИЛТЫН АЖЛААС

Баянгол дүүргийн хэмжээнд 2003 оныг "Бүтээн байгуулалт-Хөрөнгө оруулалтын жил", 2004 оныг "Хот тохижилт-Цэцэрлэгжилтийн жил", 2005 оныг Баянгол дүүрэг үүсэн байгуулагдсаны 40 жилийн ойг угтаж "Дүүргийн хөгжилд-Бидний оролцоо" бүтээлч ажлын жил болгон "Шилдэг тохижилттой байгууллага", "Төгс гэрэлтүүлэгтэй аж ахуйн нэгж байгууллага", "Хамгийн олон модтой хороо", "Хоггүй хороо", "Шилдэг тохижилттой хүүхдийн тоглоомын талбай" зэрэг номинациар болзолт уралдааныг зарлаж, дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй хороод, худалдаа үйлдвэрлэл үйлчилгээний бүх аж ахуйн нэгж байгууллагууд, сууц өмчлөгчдийн холбоод, гэр хорооллын айл өрхүүд, нийт иргэдийн дунд хот орчны тохижилтын ажлыг өрнүүлж, нийтийн эзэмшлийн зам талбайн ногоон байгууламж, гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэн, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгоход анхааран ажиллав.

### **ЭНЭБИШИЙН ГУДАМЖ**



Энэбишийн гудамжинд 2005 онд 2000м<sup>2</sup> нөхөн зүлэгжүүлэлт хийж, 1200 м услалтын системийг сэргээн засварлахад 2.7 сая төгрөг зарцуулав.

### **ДҮҮРГИЙН "ӨНДӨРЛӨГ"**



Дүүргийн өндөрлөг дээр 2003 онд 205 м<sup>2</sup> алаг хавтан зам тавьж, 560 сөөг тарьж, 60 м<sup>2</sup> цэцгийн мандалд 2700 ширхэг цэцэг тарьж, 4 ширхэг гэрэлт дал мод, 5 ширхэг чулуун сандал, усан оргилуур шинэр байгуулсан. 2004 онд 6000 цэцэг шинээр тарьж, 220 м<sup>2</sup> нөхөн зүлэгжүүлэлт хийн, Дүүргийн эмблем бүхий гэрлэн самбарыг байрлуулсан.

2005 онд Дүүргийн өндөрлөгийн нийт 5000 м<sup>2</sup> зүлэгжүүлэлтийг арчилж тордон, 2000 цэцэг шинээр тарьж, 300м хайс шинээр сольж тохижуулах ажлыг гүйцэтгэв.





## АРД АЮУШИЙН ӨРГӨН ЧӨЛӨӨ



2004 онд 552 ширхэг мод, 6000 цэцэг бүхий цэцгийн мандал, 20000 м<sup>2</sup> талбайд зүлэгжүүлэлт хийж, Өргөө кинотеатраас Саппорогийн аюулгүйн тойрог хүртэл 3200 м услалтын систем шинээр байгуулж, 400 м хайс суурилуулж, хайсны дотор талаар 50000 ширхэг сөөг суулгаж тарьсан.

2005 онд 420 улиас нөхөн тарьж, 3000м<sup>2</sup> талбайг нөхөн зүлэгжүүлж, өмнөх онд тавигдсан 3200 м услалтын системийг сэргээн засварласан .

## ЭНХ ТАЙВАНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ



Нийслэлийн гол гудамж болох Энхтайваны өргөн чөлөө нь манай дүүргийн нутаг дэвсгэр дээр баруун 4 замаас Аюулгүйн тойрог хүртэл үргэлжилсэн 3000 м урт замыг хамарсан томоохон гудамж юм.

2003 онд 8500 у/метр хайс шинээр хийж, 350 мод тарьж, 1160 м услалтын систем сэргээн засварлан ногоон байгууламжийн тохижилтын ажлыг гүйцэтгэсэн бөгөөд 10 000 м<sup>2</sup> талбайд алаг хавтан явган хүний замыг тавьсан. 2004 онд 1500 м<sup>2</sup> талбайд нөхөн зүлэгжүүлэлт хийж, 1600 сөөг, 20 мод нөхөн тарьж, 24 цэцэгийн мандал байгуулсан.

2005 онд ногоон байгууламжийн арчилгааны ажлаар, 3 дугаар сараас эхлэн 335 мод ба 500 у/метр ургамлан хашлагыг хэлбэржүүлэн тайрсан. Голланд улсын буцалтгүй тусламжаар Улаанбаатар хотын амьдрах орчныг сайжруулах төслийн хүрээнд Энхтайваны өргөн чөлөөний аюулгүйн тойрог дээр 5600 м<sup>2</sup> зүлэгжүүлэлт хийн, сөөг, цэцэгийн мандал байгуулж, “Нэг дэлхийн хүмүүс” архитектурын байгууламж, 263 м<sup>2</sup> алаг хавтан явган хүний замыг барьж байгуулах ажлыг гүйцэтгэж байна.





## АМАРСАНААГИЙН ГУДАМЖ



БНСУ-ын Сөүл хотын Чунгу дүүргийн хөрөнгө оруулалтаар 2005 оны 1 дүгээр сард 20 ширхэг гэрэлтүүлгийг шинээр суурилуулж, хаврын тариалалтаар 890 м услалтын систем угсран 4000 м<sup>2</sup> талбайг зүлэгжүүлж, 2000 у/м хайсыг сэргээн засварлаж будах зэрэг ногоон байгууламжийн тохижилтын ажлыг гүйцэтгэв.



МҮЭСТО-ны баруун талд байрлах Бага Амарсанаагийн гудамжинд 2003 онд 42 ш улиас, 900 м<sup>2</sup> зүлэгжүүлэлт хийж, 156м хайс шинээр хийсэн. 2005 онд Баянгол Тохижилт Үйлчилгээний компани Дүүргийн 40 жилийн ойг угтаж, өөрсдийн хөрөнгөөр 40 нарс, 800 сөөг тарьж, 800 м<sup>2</sup> талбайг зүлэгжүүлэн, 40м<sup>2</sup> цэцгийн мандалд нэг наст цэцэг тарьсан. 156 у/метр хайсыг сэргэн засварлаж будаж, явган хүний зам дагуу 10 ш гэрэлтүүлгийг суурилуулан иж бүрэн тохижилтын ажлыг хийж бэлэг барилаа.

## ЗАНАБАЗАРЫН ГУДАМЖ



2004 онд Улаанбаатар - Өртөөний хамт олон Нийслэлийн 365 жилийн ойг угтаж 365 мод тарьж, 800 у/метр автозамыг 1.5 метрээр өргөтөж засварлан, дүүргийн хөрөнгөөр 2130 м хайс шинээр хийв.

2005 онд Голланд улсын буцалтгүй тусламжаар Улаанбаатар хотын амьдрах орчныг сайжруулах төслийн хүрээнд Занабазарын гудамжинд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг гүйцэтгэж байна. Цэцэрлэгт хүрээлэнд 340 мод, 1640 бут сөөг, 24 сандал, 1100 м<sup>2</sup> явган хүний зам, 45м<sup>2</sup> автомашины зогсоол байгуулах ажлуудыг гүйцэтгэнэ.





## АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГУУДЫН ТОХИЖИЛТ



Замчны гудамжинд байрлах Худалдаа үйлдвэрлэл үйлчилгээний Ган зам худалдааны төв нь 165 м<sup>2</sup> талбайд хайлаас, шар хуайс тарьж, 40ш гэрэл, 200 м туузан гэрэл хийж, 31 сая.төгрөгний тохижилт хийсэн.



Амарсанаагийн гудамжинд байрлах Од кинотеатр нь 899 м<sup>2</sup> талбайд өнгөт хавтан суулган, 52.7 м<sup>2</sup> талбай засч, гадна талбайд 590.0 мян.төгрөгний реклам чимэглэл хийж, 9.200 мян.төгрөгний өртөг бүхий хашаа хийж, нийт 21.132сая.төгрөгний тохижилтын ажил хийсэн



Нарны гудамжинд байрлах **Зорчигч Үйлчилгээний Улаанбаатар Буудал** нь нийт 1.5 тэрбум төгрөгний тохижилтын ажлаар өөрийн байрандаа 175 сая төгрөгний өртөг бүхий зар сурталчилгааны телевиз байрлуулж, авто талбайн гарах хаалганд автомат хаалт хийж, зорчигчдын танхимд 300 ш ширээ сандлуудаар шинэчлэн сольж, 1000 м<sup>2</sup> явган хүний зам талбайг шинэчлэн, 1300 м<sup>2</sup> ногоон бүс буй болгож, бут сөөг зүлэг тарьсан. Мөн зорчигчдын өндөрлөсөн тавцан, нүхэн гарцын цогцолборыг 1 тэрбум төгрөгөөр хийлээ.